Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,418.1 сая төгрөг болж 636.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,113.4	668.7	-444.7
Авлага	259.7	230.0	-29.7
Бараа материал	514.7	629.2	114.5
Үндсэн хөрөнгө	1,893.7	2,890.2	996.5
Нийт хөрөнгө	3,781.5	4,418.1	636.6
Өр төлбөр	1.7	77.9	76.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,779.8	4,340.2	560.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,781.5	4,418.1	636.6

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 668.7 сая төгрөг болж, өмнөх оноос 444.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	1,113.4	668.7	-444.7
Төгрөг	1,113.4	668.7	-444.7
Төрийн сангийн харилцах	1,113.4	668.7	-444.7
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Гадаад валют	-	-	-
Арилжааны банк дахь харилцах	-	-	-
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	1,113.4	668.7	-444.7

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 668.7 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого 209.0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 314.1 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 145.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 230.0 сая төгрөг болж, өмнөх оноос 29.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	2.8	5.8	3.0
Хувь хүмүүсээс авах авлага	1.0	0.27	-0.73
Зээлийн авлага	255.9	223.8	-32.1
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/		-	
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага			
Дүн	259.7	230.0	-29.7

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт нөлөөлсөн байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 629.2 сая төгрөг болж, өмнөх оноос 114.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	-	-	-
Тусгай зориулалттай материал	-	-	-
Эм боох материал	-	-	-
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
Бэлэн бүтээгдэхүүн	-	-	-
Хангамжийн материал	497.7	612.2	114.5
Бичиг хэргийн материал	1,9	1,7	-0.2
Аж ахуйн материал	220,1	309,2	89.1
Сэлбэг хэрэгсэл		5,7	5.7
Түлш, шатах тослох материал	0	1,3	1.3
Барилгын засварын материал	0	0	0
Хүнсний материал	0	46.0	46.0
Бусад хангамжийн материал	275.5	294.0	19.5
Мал амьтад	16.9	16.9	0
Дүн	514.6	629.1	114.5

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл дансны өсөлтөд аж ахуйн материал, хүнсний материалын өсөлт гол нөлөө үзүүлсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,890.2 сая төгрөг болж, өмнөх оноос 996.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,338.7	2,001.7	663
Хуримтлагдсан элэгдэл	-494.0	-571.7	77.7
Авто тээврийн хэрэгсэл	364.2	370.4	6.2
Хуримтлагдсан элэгдэл	-125.6	-172.8	47.2
Машин тоног төхөөрөмж (компьютер)	357.8	417.7	59.9
Хуримтлагдсан элэгдэл	-166.1	-182.4	16.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	49.5	49.5	0
Хуримтлагдсан элэгдэл	-30.2	27.5	-2.7
Зам, гүүрийн байгууламж			
Хуримтлагдсан элэгдэл			
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	0	0	0.00
Дуусаагүй барилга байгууламж	71.4	71.4	0.00
Номын фонд	0	0	0.00
Бусад үндсэн хөрөнгө	551.1	1,006.2	455.1
Хуримтлагдсан элэгдэл	-175.4	-228.2	52.8
Программ хангамж	2.1	7.1	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-2.1	-3.1	1.0
Бусад биет бус хөрөнгө	151.8	151.8	0
Хуримтлагдсан элэгдэл			
Дүн	1,893.7	2,890.2	996.5

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,890.2 сая төгрөг болж 996.5 сая төгрөгөөр өсөхөд хөрөнгө оруулалт болон сумын ойн хүрээнд хандивын хөрөнгө нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Тайлант онд худалдаж авсан хөрөнгө 17.1 сая, хандив тусламжаар 500.0 сая, бусад эх үүсвэрээс 725.8 сая, нийт 1,242.9 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгджээ. Байгууллагын данс хооронд шилжүүлсэн хөрөнгө байхгүй, аймгийн болон сумын ИТХ-ын тогтоолоор 52.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 77.9 сая төгрөг болж, өмнөх оноос 76.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилтнуудтай холбоотой өглөг	0.3	0.16	-0.14
Байгууллагад төлөх өглөг	1.4	72.8	71.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг			
Хувь хүмүүст төлөх өглөг		4.9	4.9

Дүн	1.7	77.8	76.2
-----	-----	------	------

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 77.8 сая төгрөг болж 76.1 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх болон ажиллагсдад төлөх өглөг нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2025 оны түлш халаалтын зардалын 11, 12 саруудыг төлж чадаагүй өр үүссэн нь гол нөлөөг үзүүлж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын албан томилолтын зардал дутуу санхүүжилт өгсөн тул өр үүссэн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,340.2 сая төгрөг болж, өмнөх оноос 560.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	870.9	870.9	0.00
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	2,586.9	3,147.3	560.4
Өмнөх үеийн үр дүн	1,289.1	2,591.8	1,302.7
Тайлант үеийн үр дүн	1,297.8	555.5	-742.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322.0	322.0	0.00
Дүн	3,779.8	4,340.2	560.4

Эх сурвалж: Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,340.2 сая төгрөг болж 560.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Наранбулаг сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 5/03 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 647.2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 644.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.6 хувиар биелүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Нэгтгэл тайланд хамрагдсан сумын ЗДТГ-т хийсэн аудитаар 12.1 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

1. Наранбулаг сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмын 2.2-д "түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байсанд албан шаардлага өгсөн.
2. Наранбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 12.1 сая төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэсэн заалт болон толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэсэн.

Нэгтгэл тайланд тогтмол зардлын түвшинд хамрагдсан Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургуульд хийсэн аудитаар нийт 53.5 сая төгрөгийн 2 алдаа илэрсэнд залруулга хийсэн. Үүнд

1. Наранбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 25,976.9 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалт болон толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэсэн.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд түлш халаалтын зардлыг 27,500.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх” гэж заасан болон Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэсэн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,862.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,862.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,837.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,679.8 сая төгрөгийг урсгал зардалд, 1,026.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 131.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 447.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,530.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 36.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 435.8 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,602.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 78.1 сая төгрөгийг үндсэн ажиллагааны орлогоос, нийт 2,116.6 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,561.4 сая төгрөг буюу 90.3 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 101.2 сая төгрөгөөс 30.3 сая төгрөгийг зарцуулж, 70.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,533.5 сая төгрөгийн 1 хувиар буюу 45.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 36.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,800.7 сая төгрөгийн 1 хувиар буюу 48.0 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 38.4 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроож 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд хуулиар хориглосон зардал гаргасан дараах зөрчилд холбогдуулан сумын Засаг даргад хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв. Үүнд:

Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 5.6 сая төгрөг буюу 0.6 сая төгрөг илүү зарцуулсан, 05/03 дугаар тогтоолоор батлагдсан ажлын жагсаалтад байхгүй Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг өмнөх онд иргэдэд зээлээр борлуулсан өвсний үнийн эргэн төлөлтөөс шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 60 дугаар зүйлийн 60.3 дахт хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, **орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал**, арга хэмжээ” гэж заасанд нийцэхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,382.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 1,729.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгснөөс 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0			
Албан шаардлага	3	1,382.8	2	1,382.8	66.7%
Зөвлөмж	1	1,729.9	1	1,729.9	100%
Нийт дүн	4	3,112.7	3	3,112.7	

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Наранбулаг сумын Засаг даргын тамгын газраас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй 4 багийн сахиулыг гэрээтээр ажиллуулж байна. Дараагийн аудитаар тухайн гэрээт ажилтнуудын орон тоог Төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулсан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн 2 төсвийн байгууллага, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайланг нэгтгэгдсэн.

Аудитад хамрагдсан Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа орон нутгийн 2 байгууллагаас 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгч, 1 байгууллага, 2 санг түүвэрт хамруулсан байна.

Нэгтгэлд хамрагдсан харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 12.1 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 12.1 сая төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЗДТГ	2	12.1	1	12.1			1	0		
2	ИТХ										
		2	65.5	1	12.1			1	0		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт:

- Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 5.6 сая төгрөг буюу 0.6 сая төгрөг илүү зарцуулсан байна.

Зөвлөмж:

- Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг мөрдөн батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах.

Илрүүлэлт:

- Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор батлагдсан ажлын жагсаалтад байхгүй Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг өмнөх онд иргэдэд зээлээр борлуулсан өвсний үнийн эргэн төлөлтөөс шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахт хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн

хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, **орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал**, арга хэмжээ” гэж заасанд нийцэхгүй байна.

Зөвлөмж:

- Сумын ИТХ-аар орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал гаргахгүй байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор манай байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Наранбулаг сумын ТТЗ	2	13.6					2	13.6				
Дүн	2	13.6					2	13.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Наранбулаг сум								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Наранбулаг сум	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Нийт дүн	1	0			1	0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

/Т.НАМЖИЛ/



2026 оны 03 сарын 24-ний өдөр

**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХУУДАС**

А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1.Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Увс аймгийн Наранбулаг сумын ТТЗ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2026/019/НА-СТА-ТТЗ
-----------------	--	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	---	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар		1.6 Огноо	2026.03.25	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	
-----------------------------	--	-----------	------------	----------------------------	--

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 5.6 сая төгрөг буюу 0.6 сая төгрөг илүү зарцуулсан, 05/03 дугаар тогтоолоор батлагдсан ажлын жагсаалтад байхгүй Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг өмнөх онд иргэдэд зээлээр борлуулсан өвсний үнийн эргэн төлөлтөөс шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль		
	Заалт	42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”			

	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 дэх заалт
		Заалт	4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"

1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		1.10 Зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд		
	Тухайн байгууллагын дансанд		
	Зөрчил арилгах		
			2026.04.20

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл


№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Засаг даргын захирамжууд	A/196, A/212, A/47, A/206, A/207, A/208, A/236	2025.09.23, 2025.10.14, 2025.04.18 2025.10.03 2025.10.03 2025.10.03 2025.11.19	Санхүүжилт олгох тухай
2	Холбогдох анхан шатны баримт		2025 он	Төлбөрийн хүсэлт, нэхэмжлэх, хуулга
3	Санхүүгийн албаны даргын тайлбар		2026.03.24	100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл


№	Аудитын багийн		Хариуцагч			
	Албан тушаал	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Ахлах аудитор	Т.Намжил	Увс ТЕЗ	Аймгийн Засаг дарга	Э.Насанбат	

Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер М.Бат-Амгалан	2026.03.25		
2	Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	2026.03.25		

4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2026.03.25	

4. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт		Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар
1	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо		2026.03.25
		Ажилтны	Овог нэр	Т.Намжил
			Албан тушаал	Ахлах аудитор
3	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Увс аймгийн ТЕЗ
		Ажилтны	Овог нэр	Э.Насанбат
			Албан тушаал	Дарга
4	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Увс аймгийн ТЕЗ
		Ажилтны	Овог нэр	Э.Насанбат
			Албан тушаал	Дарга
5	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		



УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 9/56/А-2060412
УВА-2026/019/НА-СТА-ТТЗ

Улаангом

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Наранбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 5.6 сая төгрөг буюу 0.6 сая төгрөг илүү зарцуулсан, мөн батлагдсан ажлын жагсаалтад байхгүй Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг өмнөх онд иргэдэд зээлээр борлуулсан өвсний үнийн эргэн төлөлтөөс шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11.2-д “ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн байгууллага, албан тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3-т “Энэ

хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Наранбулаг сумын Засаг дарга Р.Азбилэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Увс аймгийн Засаг дарга Э.Насанбатад хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.НАМЖИЛ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ